



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (10)

2021.03.15

УНГАР УЛСТАЙ УСНЫ САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАНА



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Усны салбарт чиглэсэн хэд хэдэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүний нэг болох “Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, барилга, байгууламжийн ажлыг эхлүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд БОАЖ-ын сайд Н.Уртнасан Унгар улсын Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Борбала Обрушанскийг хүлээн авч уулзан дээрх асуудлаар санал солилцжээ.

Уулзалтаар талууд “Хөх морь” төслийг хамтран хэрэгжүүлж, гадаргын усны хуримтлалыг бий болгох замаар ус хангамжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллахаар санал нэгдсэн байна.

[Эх сурвалж: БОАЖЯ](#)

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Б.МӨНХБААТАР НИЙСЛЭЛ БОЛОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ ҮЗЭГЛЭЛЭЭ



Барилга, хот байгуулалтын салбарын төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулах, орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тухай хамтын ажиллагааны хүрээнд салбарын сайд Б.Мөнхбаатар аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2021 оны хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж баталгаажууллаа. Энэхүү хамтран ажиллах гэрээний хүрээнд нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн чиглэлээр “Цэвэр бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ын хэрэгжилтийг хангахад тус яам болон Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллах, “Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн газрын 2012 оны 209 дүгээр тогтоолыг аймгуудад хэрэгжүүлэх, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 (Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх) дугаар зүйл, 17 (Ус хангамж, ариутгах татуурга), 18 (Цэвэрлэх байгууламж, бохир ус) дугаар зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлэх, Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг тусгасан байна.

[Эх сурвалж: БХБЯ](#)

ДЭЛХИЙН УСНЫ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН “ХУУРАЙ ҮЕР” ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛНА



Жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр дэлхийн нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлдэг Дэлхийн Усны өдрийг тохиолдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Соёлын яамны дэмжлэгтэйгээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Монголын Байгалийн Уран Бүтээлчдийн Холбоо (Mongolian Nature Artists) хамтран "Усны үнэлэмж, үнэ цэнэ" уриан дор “ХУУРАЙ ҮЕР” сэдэвт контемпорари үзэсгэлэн зохион байгуулж байна. Үзэсгэлэн 2021 оны 3 дугаар сарын 15-наас 22-ны хооронд Занабазарын Нэрэмжит Дүрслэх Урлагийн Музейд гарна. Мөн <https://www.mn-artists.com/> сайтаар дамжуулан цахим хэлбэрээр тус үзэсгэлэнг үзэж сонирхох боломжтой юм байна.

[Эх сурвалж: Монголын Байгалийн Уран Бүтээлчдийн Холбооны фэйсбүүк хуудас](#)

ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨРТ ЗОРИУЛСАН ЦАХИМ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

- Дэлхийн Усны өдөр буюу 3 дугаар сарын 22-ны өдөр НҮБ-ын Усны агентлагаас цахим арга хэмжээ зохион байгуулна. Арга хэмжээний үеэр уламжлал ёсоор НҮБ-аас жил бүр гаргадаг Дэлхийн усны хөгжлийн тайланг танилцуулна. Мөн Стокгольмын усны шагналын эзнийг зарлана. [Эх сурвалж: unwater.org](http://unwater.org)
- “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ийн устай холбоотой зорилтуудын биелэлтийг хэлэлцэх нэг өдрийн дээд хэмжээний уулзалтыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Ерөнхийлөгчийн санаачилгаар 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын төв байранд зохион байгуулна. [Эх сурвалж: un.org](http://un.org)
- Усны музейнүүдийн дэлхийн сүлжээнээс санаачлан ЮНЕСКО, Оксфордын их сургууль болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр “Ус ярих цаг дор” сэдэвт вэбинарыг 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатарын цагаар 17:30–19:00 цагт зохион байгуулна. Вэбинарт усны салбарын эрдэмтэн судлаачдаас гадна Сент-Жонсын Оркестрын хөгжимчид оролцож, уран бүтээлээ хүргэх бөгөөд <https://www.watermuseums.net/news/when-waters-speak-international-webinar-valuing-water-through-art-and-science/> холбоосоор дэлгэрэнгүй мэдээллийг авч, бүртгүүлэх боломжтой. [Эх сурвалж: watermuseums.net](http://watermuseums.net)